



Админтай ажиллах гарын авлага

Нэвтрэх хаяг: <https://accounts.greensoft.mn/>


## 1.ТОХИРГОО

	<p><b>ЗУРАГ 1.</b> Админ dashboard хэсэгт “Тохиргоо” гэсэн хэсэг байгаа бөгөөд эндээс сайтын үндсэн тохиргоог засна.</p>
---	--


**ЗУРАГ 2. Үндсэн мэдээлэл цэс** - Энэ цэсэнд утас, имэйл, холбоо барих хаяг, хамгийн доод хэсэг фэйсбүүк, инстаграм гэх зэрэг социал хаягынхаа линкийг энд оруулна. Тэгээд хадгалах дарвал эдгээр мэдээллүүд өөрчлөгдөнө.



**ЗУРАГ 3. Вэбийн тохиргоо цэс** - Энэ хэсэгт вэбийн header footer хэсэг болон үндсэн сайтын өнгө тохируулах, үсгийн фонтыг тохируулж болно. Бусад тохиргоонуудыг оролдож болохгүй гэдгийг анхаарах.




**ЗУРАГ 4. Лого/Нэмэлт CSS вэс** - Энэ хэсэгт байгууллагын логог солино. Логоноос доошоо байгаа код бичсэн хэсэгтэй оролдож болохгүй.



**GREENSOFT** БАТЛАВ. ГРИЙН СОФТ ХХК

## 2. ХУУДАС (вэбийн үндсэн хуудас, меню-г засах)




**ЗУРАГ 1.**  
 Вэб сайтын харагдаж байгаа бүх хуудсуудыг хуудас гэсэн энэхүү цэснээс засна. Тухайлбал, бидний тухай хуудас дээр очиж “засварлах” товчыг дарснаар дотор нь байгаа текст зураг мэдээллүүд гарч ирнэ. Ингээд эндээс мөн засах гэж дараад өөрийн засах гэж байгаа хэсгийг өөрчилж “нийтлэх” товчыг дарна.

## 3. НИЙТЛЭЛ, БЛОГ ОРУУЛАХ, ЗАСВАРЛАХ

	<p><b>ЗУРАГ 1.</b>  Вэб сайтдаа мэдээ, нийтлэл, блог оруулахдаа “Нийтлэл” гэсэн цэсэн дээ дарна. Шинэ нийтлэл оруулахдаа “Шинэ пост оруулах” эсвэл “Нэмэх” гэсэн хэсэгт дарж гарч ирэх талбар дээр мэдээллээ оруулна.</p>
--	---



	<p><b>ЗУРАГ 2.</b>  Мэдээндээ ангилал өгөх бол “Нийтлэл”-ийн доор байгаа “Ангилалууд” хэсэгт дарж зурагт үзүүлснээр “Нэр” хэсэгт ангиллын нэрээ бичнэ. Жишээ нь: Зөвлөгөө, цаг үеийн мэдээ, гэх мэт.</p>
---	--



### ЗУРАГ 3.

Шинэ мэдээ нэмэх “Шинэ пост оруулах” товчыг дарж мэдээ нэмэхээр ороход ийм цонх танд харагдана. “Гарчиг” хэсэгт гарчиггаа бичнэ. Мэдээ оруулахад гарчиг, нийтлэлийн ковер зураг, товч агуулаг, ангиллыг заавал оруулж байж нийтлэгдэнэ. Хэрэв оруулахгүй бол нийтлэгдэхгүй сануулга гарч ирнэ. Нийтлэл ковер зураг хэсэгт үндсэн зургаа, “choose file” гэж сонгоод оруулна. Ковер зургийн доор “Товч агуулга хэсэг байгаа бөгөөд энд 1 өгүүлбэрт багтааж нийтлэлийнхээ товч агуулгыг оруулна. Үүнийг доошоо “Ангилал” гэсэн хэсэг байгаа бөгөөд эндээс нийтлэл тань аль ангилал орохыг сонгоно. Үүний дарааг “Rich text нээх” гэсэн үг




БАТЛАВ. ГРИЙН СОФТ ХХК

<p>Товч агуулга</p> <div style="border: 1px solid #ccc; padding: 5px; min-height: 40px;">       Lorem Ipsum is simply dummy text of the printing and typesetting industry.     </div> <p>Мэдээний төрөл</p> <div style="border: 1px solid #ccc; padding: 5px;">       Текст мэдээ     </div> <p><b>Ангилал</b></p> <p><input checked="" type="checkbox"/> Ангиллагдаагүй</p> <p><input type="checkbox"/> Ангилал 1</p>	<p>гарчигын доор байрлах бөгөөд энэ хэсэг эхлээд ороход шууд нээгдэхгүй тул заавал энэ үг дээр дарж байж үндсэн текст оруулах зураг харуулсан хэсэг гарч ирнэ. Зургийг сайн харна уу.</p>
--	---

#### 4.СЛАЙДЕР БУЮУ НҮҮРНИЙ ТОМ ЗУРАГ СОЛИХ

Вэб сайт руу ороход үндсэн цэс, логоны доор байрлах хэсгийг “слайдер” гэнэ. Слайдерт оруулах зураг нь 1920x500px-тэй байвал тохиромжтой. Слайдер зураг - Тухайн хугацаанд хамгийн чухал бараа, бүтээгдэхүүн, хямдрал урамшууллын мэдээллийг агуулсан хэрэглэгчийг уриалсан утга санаа бүхий байна. Энэ нь хамгийн ихдээ 3-5 ширхэгээс хэтрэхгүй байвал зүгээр байдаг. Хэт олон слайдер зураг ачаалал үүсгэх магадлалтай байдаг. Слайдерыг бэлдэхдээ үндсэн текст, зурган мэдээллийг гол хэсэгтээ төвлөрүүлнэ бэлдэх шаардлагатай анхаарна уу.



	<p><b>ЗУРАГ 1.</b>  Вэб сайтын админ дээр “Слайдер” гэх цэс байгаа бөгөөд үүн дээр дарвал “Слайдууд” хэмээн задарна. Энд дарснаар танд зураг 2-т харуулах дэлгэц гарч ирнэ.</p> <p><b>ЗУРАГ 2.</b>  Зураг 2-т слайдерыг удирдах хэсэг байгаа бөгөөд “Шинэ зураг нэмж хасах” гэсэн товч дээр дараад цааш үргэлжлүүлнэ.</p> <p><b>ЗУРАГ 3.</b>  Ингээд шинэ слайдер зураг нэмэх хэсэг гарч ирэх бөгөөд “Choose file” дарж зургаа сонгож оруулна. Зураг сонгохдоо доод талын зааврын заавал уншина.</p>
--	--

БАТЛАВ. ГРИЙН СОФТ ХХК

	<p>Desktop-д гарах зураг - гэдэг нь компьютераас сайтанд орох үед харагдах зураг Mobile-д гарах зураг - гэдэг нь гар утаснаас сайтанд орох үед харагдах зураг бөгөөд desktop дээрх зургаас өөр дизайнтай байж болно</p>
--	---

## 5. ФОРМ

Форм бол вэб сайтад хэрэглэгчийн мэдээлэл цуглуулах, авах хэсэгт ашиглагддаг бөгөөд энэ хэсгийг ашиглан та танай бүтээгдэхүүн үйлчилгээг сонирхож буй хүмүүсийн нэр,утас, имэйлийг авах боломжтой. Админ дээрээс форм үүсгэхдээ доорх алхамын дагуу хийнэ.

**ЗУРАГ 1.** Админ дээрх “Форм” цэс рүү орно.

БАТЛАВ. ГРИЙН СОФТ ХХК

**ЗУРАГ 2.**

Форм цэсрүү орвол танд дараах хэсэг харагдах бөгөөд “Шинэ лист үүсгэх” гэж дарна шинээр форм үүсгэнэ. Харин одоо байгаа формын мэдээллийг үзэх бол “Дата үзэх”, форм засварлах бол “Форм засварлах” хэсэгт дарна.

**ЗУРАГ 3.**

Шинээр форм үүсгэх товчыг дарсны дараа доорх зурагт үзүүлсэн хэсэг гарч ирэх бөгөөд формын нэр болон тайлбар хэсгийг заавал бөглөнө. Ингээд хэрэглэгчээс нэр, утас, имэйлийн мэдээллийг нь авах бол тус бүрийг чек хийнэ. Товч мэдээлэл бичүүлж авах бол “Агуулга” хэсгийг нэмэлтээр чек хийж болно. Формын доор “Хүлээн авах имэйл хаяг” гэсэн хэсэг байгаа бөгөөд энэ хэсэгт форм бөглөхөд мэдээллийг нь байнга хүлээх авах байгууллагын имэйлээ бичнэ. Олон имэйл дээр мэдээллийг авч байхыг хүсвэл зааврын дагуу таслал тавиад дараагийн имэйлийг бичиж болно. Ингээд хадгалах дарна. Үүсгэсэн формоо хаана гаргахаасаа

	<p>хамаарч холболтыг тусдаа хийнэ.</p>
--	--

БАТЛАВ. ГРИЙН СОФТ ХХК

## Нэмэлт query бичих ЗААВАР

Бүтээгдэхүүний блокоор сайтанд бүтээгдэхүүн гаргах түлхүүр бичиглэл дараах бичиглэлийг блокын Нэмэлт query хэсэгт дараах байдлаар бичнэ.

### Тусгайлан нэг ангилалыг гаргаж ирэхэд

=====

&category\_id=1234

(тайлбар 1234 гэдэг нь жишээ ангилал бөгөөд ангилалын дугаарыг админ хэсгийг бүтээгдэхүүний ангилал цэсний дотороос бүтээгдэхүүний ангилалын ард байрлах 4-5 нь оронтой тоог гэж ойлгоно.)

### Брэндээр шүүхэд

=====

&brand\_id=1234

(тайлбар 1234 гэдэг нь жишээ брэнд бөгөөд брэндийн дугаарыг админ хэсгийг бүтээгдэхүүний брэнд цэсний дотороос бүтээгдэхүүний брэндийн ард байрлах 4-5 нь оронтой тоог гэж ойлгоно.)

### Тагаар шүүхэд

=====

&tag\_id=1234

(тайлбар 1234 гэдэг нь жишээ таг бөгөөд тагийн дугаарыг админ хэсгийг бүтээгдэхүүний таг цэсний дотороос бүтээгдэхүүний тагийн ард байрлах 4-5 нь оронтой тоог гэж ойлгоно.)

### Хямдралтай бүтээгдэхүүн

=====

Зөвхөн хямдралтай бүтээгдэхүүнүүдийг гаргах

&is\_sale=1

Хямдралгүй бүтээгдэхүүн

&is\_sale=0

### Топ бүтээгдэхүүн

=====

Зөвхөн топ бүтээгдэхүүнүүдийг гаргах

&is\_top=1

Топоос бусад бүтээгдэхүүн

&is\_top=0

### Онцлох бүтээгдэхүүн

=====

Зөвхөн онцлох бүтээгдэхүүнүүдийг гаргах

&is\_featured=1

Онцлохоос бусад бүтээгдэхүүн

&is\_featured=0

### Шинэ бүтээгдэхүүн

=====

Зөвхөн шинэ төлөвтэй бүтээгдэхүүнүүдийг гаргах

&is\_new=1

Шинээс бусад бүтээгдэхүүн

&is\_new=0

**Гарч ирэх бүтээгдэхүүнийг тоог зааж өгөх**

=====

&limit=50

Эдгээр утгуудыг бүгдийг нь хооронд нь нийлүүлж бичих замаар хүссэн бүтээгдэхүүнээ гаргаж ирнэ.

Жишээ нь: &category\_id=1234&is\_sale=1&is\_new=0&limit=10 гэж бичнэ. Энэ нь 1234 дугаартай ангилалын шинэ биш бараануудаас хямдралтай сүүлийн 10 бүтээгдэхүүнийг авч байна.